



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2026 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/392

Улаанбаатар хот

МУИС-ийн шагнал, урамшууллын
нийтлэг журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3 дахь заалт, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь заалт, МУИС-ийн Ректорын зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "МУИС-ийн шагнал, урамшууллын нийтлэг журам"-ийг хавсралтаар баталж, 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс мөрдсүгэй.

2. Захирлын (Ректорын) 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/127 дугаар тушаалын хавсралтаар баталсан "МУИС-ийн шагнал, урамшууллын нийтлэг журам"-ийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү журмын хэрэгжилтийг зохион байгуулах, шагнал урамшууллын үйл ажиллагааг журамд нийцүүлэн хэрэгжүүлэхийг бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал (Б.Болд-эрдэнэ, Б.Амарсанаа, Н.Батнасан, Б.Ганбат, Ч.Сономдагва, С.Мөнхбат, Ц.Пүрэвсүрэн, Д.Алтанхуяг, Б.Мядагмаа) болон холбогдох газрын дарга (П.Лхамсүрэн, С.Должин, А.Баатарбилэг, С.Булгантамир, Б.Цэцэнцолмон, Г.Цэрэн, Н.Эрдэнэ, Ш.Мэндбаяр, Д.Бадмаанямбуу, Н.Халиун, Б.Шижиржаргал) нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар), Судалгаа, хамтын ажиллагаа эрхэлсэн проректор (Ц.Баатарчулуун), Төлөвлөлт, хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор (Б.Даваасүрэн), Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (С.Должин) нарт даалгасугай.

РЕКТОР  Б.ОЧИРХУЯГ

ATA13089 9104399
9024080427

1426133033

Монгол Улсын Их Сургуулийн ректорын
2026 оны 09 дүгээр сарын 28-ны/ний өдрийн
А/392 дугаар/дүгээр тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ШАГНАЛ, УРАМШУУЛЛЫН НИЙТЛЭГ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Монгол Улсын их сургуулийн стратеги төлөвлөгөө, хүний нөөцийн бодлого, сургалт, судалгаа, инновац, нийгэмд үзүүлэх үйлчилгээний зорилттой уялдуулан багш, ажилтан, суралцагч, хамтран ажиллагч байгууллага, хувь хүний оруулсан хувь нэмэр, бүтээлч үйл ажиллагааг үнэлэх, шагнал, урамшуулал олгоход энэхүү журмын зорилго оршино.

1.2 Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, МУИС-ийн дүрэм, хөдөлмөрийн дотоод болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн мөрдөнө.

1.3 Энэхүү журам нь МУИС-ийн багш, эрдэм шинжилгээний ажилтан, захиргаа, үйлчилгээний ажилтан, суралцагч, хамтран ажиллагч байгууллага, хувь хүнд шагнал, урамшуулал олгохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.4 Шагнал, урамшуулал олгохдоо дараах зарчмыг баримтална:

- 1.4.1. Мерит буюу мэдлэг, ур чадвар, бодит үр дүнд суурилсан байх;
- 1.4.2. Тэгш боломж, үл ялгаварлах зарчим баримтлах;
- 1.4.3. Ил тод, нээлттэй, хариуцлагатай байх;
- 1.4.4. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 1.4.5. Хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх;
- 1.4.6. Баримт, нотолгоонд тулгуурлан үнэлэх;
- 1.4.7 Шагнал, урамшуулал олгох үйл ажиллагаа нь шударга байх;
- 1.4.8 Шагнал, урамшууллын төрөл, болзол, шалгуур, нэр дэвшүүлэх хугацаа, шалгаруулалтын үе шат, шагнал олгосон шийдвэрийг ил тод мэдээлнэ.

1.5 Монгол Улсын төрийн дээд цол, одон, медаль, Засгийн газрын шагналд нэр дэвшүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ХОЁР. МУИС-ИЙН ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

2.1. МУИС-ийн шагнал, урамшуулал нь дараах төрөлтэй байна:


- 2.1.1. хүндэтгэлийн болон ёслолын шагнал;
- 2.1.2. гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшуулал;

- 2.1.3. судалгаа, эрдэм шинжилгээ, инновацын шагнал, урамшуулал;
2.1.4. хамтын ажиллагааны шагнал.

2.2. Хүндэтгэлийн болон ёслолын шагналыг байгууллагын үнэт зүйл, байгууллагын хөгжилд оруулсан урт хугацааны хувь нэмэр, нэр хүнд, манлайлал, ёс зүй, байгууллагын уламжлал, түүхэн гавьяаг үндэслэн олгоно.

2.2.1. Хүндэтгэлийн шагналд дараах шагнал хамаарна:

- 2.2.1.1. “Эрдмийн элч” медаль;
2.2.1.2. “Хүндэт дэвтэрт алдаршуулах”;
2.2.1.3. “Хүндэт жуух”;
2.2.1.4 “Баярын бичиг”



2.3. Гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшууллыг байгууллагын стратеги төлөвлөгөө, KPI, ажлын үр дүн, чанар, бүтээмжийг үндэслэн олгоно.

2.3.1. Гүйцэтгэлд суурилсан урамшууллыг дараах чиглэлээр олгож болно:

- 2.3.1.1. оны шилдэг багш;
2.3.1.2. оны шилдэг ажилтан /захиргааны ажилтан, үйлчилгээний ажилтан/;

2.4. Судалгаа, эрдэм шинжилгээ, инновацын шагнал, урамшууллыг судалгааны чанар, инновац, технологи дамжуулалт, олон улсын түвшин, шинжлэх ухааны нөлөөлөл, мэдлэг бүтээх, эдийн засгийн эргэлтэд оруулсан байдлыг үндэслэн олгоно.

2.4.1. Судалгаа, эрдэм шинжилгээ, инновацын шагнал, урамшуулалд дараах урамшуулал хамаарна:

- 2.4.1.1. Өндөр импакт бүхий бүтээлийн урамшуулал
2.4.1.2. Шилдэг бүтээлийн урамшуулал
- Q1 ангиллын сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл
- Q2 ангиллын сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл
- Q3 болон Q4 ангиллын сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл
2.4.1.3 Шилдэг патент, ашигтай загварын урамшуулал
2.4.1.4 Шилдэг инновац, технологи дамжуулалтын үр дүнгийн урамшуулал

2.5 Хамтын ажиллагааны шагналыг стратегийн түншлэл, тогтвортой хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, судалгаа, сургалтын дэмжлэг, олон улсын хамтын ажиллагаа, нийгмийн хариуцлагыг үндэслэн олгоно.

2.5.1 Хамтын ажиллагааны шагналд дараах шагнал хамаарна:

2.5.1.1 Шилдэг түнш өргөмжлөл

2.6 Хүндэтгэлийн болон ёслолын шагналыг тухайн шагналын нэр хүнд, үнэ цэнийг хадгалах зарчмыг баримтлан хязгаартай олгож болно.

2.7 “Эрдмийн элч” медаль, “Хүндэт дэвтэрт алдаршуулах” шагналыг хичээлийн 1 жилд тус бүр 1 хүнд олгож болно.

ГУРАВ. НИЙТЛЭГ БОЛОН ТУСГАЙ ШАЛГУУР

3.1. Шагнал, урамшуулалд нэр дэвшигч нь дараах нийтлэг шалгуурыг хангасан байна:

- 3.1.1. хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчилгүй байх;
- 3.1.2. шагналын материалын бүрдүүлэлт бодит, үнэн зөв байх;
- 3.1.3. тухайн жилийн ажлын гүйцэтгэл хангалттай үнэлэгдсэн байх.

3.2. МУИС-ийн хүндэтгэлийн болон ёслолын шагнал, гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшуулал, судалгаа, эрдэм шинжилгээ, инновацын шагнал, урамшуулал, хамтын ажиллагааны шагналд нэр дэвшигч нь тухайн шагнал, урамшууллын онцлог, зорилго, үнэлгээний чиглэлтэй уялдсан Хавсралт 1-д заасан тусгай шалгуурыг хангасан байна.

3.3. “Өндөр импакт бүхий бүтээлийн урамшуулал”-д нэр дэвшигч нь МУИС-ийн үндсэн орон тооны багш, ажилтан байх бөгөөд Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд нэгдүгээр зохиогч эсхүл холбоо барих зохиогчоор хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл нь хэвлэгдсэн жилийн байдлаар Scopus мэдээллийн сангийн CiteScore Percentile үзүүлэлтээр шилдэг 10 хувьд (Percentile ≥ 90) эрэмбэлэгдсэн байна.

3.4. “Шилдэг бүтээлийн урамшуулал”-д нэр дэвшигч нь МУИС-ийн үндсэн орон тооны багш, ажилтан байх бөгөөд Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд бүтээл хэвлүүлсэн байна. Урамшууллыг сэтгүүлийн квартиль ангилал болон нэр дэвшигчийн нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч, хамтран зохиогчоор оролцсон байдлыг харгалзан Хавсралт 2-т заасны дагуу олгоно.

3.5. “Шилдэг патент, ашигтай загварын урамшуулал”, “Шилдэг инновац, технологи дамжуулалтын үр дүнгийн урамшуулал”-д нэр дэвшигч нь Хавсралт 1-д заасан тусгай шалгуур, үнэлгээний үзүүлэлтийг хангасан байна.

ДӨРӨВ. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ

4.1. Нэр дэвшүүлэх үндэслэл

4.1.1. МУИС-ийн багш, ажилтан, хамтран ажиллагч байгууллага, хувь хүнийг тухайн шагнал, урамшууллын болзол, шалгуурыг хангасан гэж үзвэл шагнал, урамшуулалд нэр дэвшүүлж болно.

4.1.2. Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх ажиллагаа нь ил тод, шударга, хамтын оролцоог хангасан байна.

4.1.3. Нэр дэвшүүлэлтийг тухайн жилийн төлөвлөгөө, тэмдэглэлт ой, мэргэжлийн баяр, онцгой амжилт, сургуулийн хөгжлийн үр дүнтэй уялдуулна.

4.2. Нэр дэвшүүлэх

4.2.1. “Эрдмийн элч” медаль, “Хүндэт дэвтэрт алдаршуулах” шагналыг тухайн нэгжийн хамт олны хурлын шийдвэрийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн тохиолдолд холбогдох материалыг хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

“Хүндэт жуух”, “Баярын бичиг” шагналыг тухайн нэгжийн хамт олны хурлын шийдвэр, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар

хэлэлцүүлэн дэмжигдсэн тохиолдолд холбогдох материалыг хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ. Захиргаа, төвлөрсөн сангийн ажилтны хувьд хамт олны хурлаар хэлэлцэн холбогдох материалыг хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

“Оны шилдэг багш”, “Шилдэг ажилтан”, “Шилдэг түнш”, “Шилдэг патент, ашигтай загварын урамшуулал”, “Шилдэг инновац, технологи дамжуулалтын үр дүнгийн урамшуулал”-ыг хавсралт 2-т заасан хариуцсан нэгж нь зохион байгуулж, холбогдох материалыг хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

4.2.2.Хуралдааны ирц, санал хураалтын шаардлагыг байгууллагын холбогдох дотоод журмаар зохицуулна.

4.2.3.Нэр дэвшүүлэх шийдвэр нь хурлын тэмдэглэл, шийдвэр, саналын хуудсаар баталгаажсан байна.

4.2.4.Өндөр импакт бүхий бүтээл, Шилдэг бүтээлийн урамшууллыг эрдэм шинжилгээний бүртгэлийн системээс судалгаа, эрдэм шинжилгээ хариуцсан нэгж онооны эрэмбээр гаргаж, ректорын зөвлөлийн хуралд танилцуулна.

4.2.5.Өндөр импакт бүхий өгүүлэл нь Web of Science Core Collection эсвэл Scopus мэдээллийн сангийн шилдэг 10 хувьд (Percentile ≥ 90 , Journal Impact Factor Percentile, CiteScore Percentile) эрэмбэлэгдсэн сэтгүүлд нэгдүгээр зохиогч эсвэл холбоо барих зохиогчоор эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байна. Сэтгүүлийн эрэмбийг тогтоохдоо тухайн өгүүлэл хэвлэгдсэн жилд Web of Science Core Collection эсвэл Scopus мэдээллийн сангаас зарласан эрэмбийг ашиглана.

4.2.6. Шилдэг бүтээлийг МУИС-ийн үндсэн орон тооны багш, ажилтны олон улсын Scopus мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн зохиогчийн оролцоо, сэтгүүлийн ангиллаас хамааруулан шалгаруулна.

4.3. Нэр дэвшигчид тавигдах шаардлага

4.3.1. Нэр дэвшигч нь энэхүү журмын нийтлэг болон тусгай шалгуурыг хангасан байна.

4.3.2. Нэр дэвшигчийн талаарх мэдээлэл, тодорхойлолт, нотлох баримт нь үнэн зөв, бодитой байна.

4.4. Бүрдүүлэх материал

4.4.1. Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэхэд дараах материалыг бүрдүүлнэ:

4.4.1.1. нэр дэвшүүлэх санал;

4.4.1.2. танилцуулга;

4.4.1.3. ажил, сурлага, судалгаа, хамтын ажиллагааны үр дүнг нотлох баримт;

4.4.1.4. холбогдох хурлын шийдвэр, тэмдэглэл;

4.4.1.5. бусад шаардлагатай материал.

4.4.2. Шагнал, урамшуулалд нэр дэвшигчийн танилцуулга маягтын загварыг энэхүү журмын хавсралт 3-т батална.

4.4.3. Материалыг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч болно.

4.5. Материал хүлээн авах, бүртгэх

4.5.1. Шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэх материалыг Захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж хүлээн авч бүртгэнэ.

4.5.2. Материал хүлээн авсан тухай бүртгэл хөтөлж, баталгаажуулна.

4.5.3. Дутуу материал ирүүлсэн тохиолдолд нөхөн бүрдүүлэх хугацаа олгож болно.

4.6. Нэр дэвшүүлэх, тодорхойлох ажиллагаанд оролцож буй этгээд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

4.7. Шагнал, урамшуулалд нэр дэвшигч болон шагнагдсан этгээдийн мэдээллийг нэгдсэн цахим санд бүртгэнэ. Хувь хүний мэдээллийг хууль тогтоомжид нийцүүлэн хамгаална.

4.8. Дараах тохиолдолд шагнал, урамшуулалд нэр дэвшүүлэхгүй:

4.8.1. сахилгын шийтгэл хүчинтэй байгаа;

4.8.2. зохиогчийн эрхийн зөрчил, судалгааны ёс зүйн зөрчил нь тогтоогдсон;

4.8.3. байгууллагад хохирол учруулсан нь тогтоогдсон.

ТАВ. ШАЛГАРУУЛАЛТ, ҮНЭЛГЭЭ

5.1. Шалгаруулалтын зохион байгуулалт

5.1.1. МУИС-ийн шагнал, урамшуулалд нэр дэвшигчийг үнэлэх, дүгнэх, шалгаруулалт нь ил тод, шударга, хараат бус, нотлох баримтад суурилсан байна.

5.1.2. Шалгаруулалтыг тухайн шагналын шалгуур үзүүлэлт, онооны систем, үнэлгээний аргачлалд үндэслэн зохион байгуулна.

5.2. Шалгаруулах ажлын хэсэг

5.2.1. Шагнал, урамшууллын шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд ректорын тушаалаар баталгаажуулна.

5.2.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухайн шагнал, урамшууллын чиглэлийн мэргэжилтэн, удирдах ажилтан, хүний нөөцийн төлөөллийг хангана.

5.3. Үнэлгээний шалгуур

5.3.1. Оны шилдэг багш, ажилтан, түншийг шалгаруулахад хавсралт 1-т заасан нэр дэвшигчид тавигдах шалгуурт үндэслэн үнэлнэ.

5.3.2. Ажлын хэсэг үнэлгээний үндэслэлээ баримтжуулсан байна.

5.4. Хуралдаан, санал хураалт

5.4.1. Ажлын хэсгийн хуралдааныг гишүүдийн олонх оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно.

5.4.2. Шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар гаргана.


5.4.3. Санал тэнцсэн тохиолдолд ажлын хэсгийн даргын санал шийдвэрлэх санал байна.

5.4.4. Хуралдааны тэмдэглэл хөтөлж, архивд хадгална.

5.5. Шалгаруулалтын дүн

5.5.1. Ажлын хэсэг шалгаруулалтын нэгдсэн дүгнэлтийг ректорын зөвлөлийн хуралд танилцуулна.

5.5.2. Ажлын хэсэг шаардлага хангаагүй нэр дэвшигчийг шалгаруулахгүй.



ЗУРГАА. ШАГНАЛ ОЛГОХ ШИЙДВЭР ГАРГАХ, ГАРДУУЛАХ

6.1. Шийдвэр гаргах

6.1.1. МУИС-ийн шагнал, урамшуулал олгох шийдвэрийг шалгаруулах ажлын хэсгийн дүгнэлтийг Ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

6.1.2. Ректорын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ректор тушаалаар баталгаажуулна.

6.2. Шагнал гардуулах

6.2.1. Шагнал, урамшууллыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээний хугацааг хавсралт 2-д заасны дагуу зохион байгуулна.

6.2.2. Шагнагдсан багш, ажилтны мэдээллийг байгууллагын дотоод болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

6.3. Мөнгөн урамшуулал

6.3.1. Шагналд дагалдах мөнгөн урамшууллыг тухайн жилийн батлагдсан төсөвтэй уялдуулан тогтооно.

6.3.2. Мөнгөн урамшууллын хэмжээ, ангилал, олгох нөхцөлийг хавсралт 2-т заасны дагуу олгоно.

6.3.3. Шилдэг бүтээлийн урамшууллыг олгоход тухайн бүтээлд нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч, хамтран зохиогчоор оролцсон МУИС-ийн хоёр ба түүнээс дээш үндсэн орон тооны багш, ажилтан байгаа тохиолдол дээрх урамшууллыг зохиогчийн оролцооноос хамааруулан судалгааны ажлыг удирдагч хуваарилан олгоно.

6.3.4. Хэрэв тухайн бүтээлд МУИС-ийн үндсэн орон тооны багш, ажилтан зөвхөн хамтран зохиогчоор оролцсон, мөн хоёр ба түүнээс дээш үндсэн орон тооны багш, ажилтан байгаа тохиолдолд дээрх урамшууллыг тэдгээрийн дунд тэнцүү хуваан олгоно.

6.3.5 Нэг бүтээлд давхардуулахгүйгээр зөвхөн нэг төрлийн урамшуулал олгоно.

6.4. Санхүүжилтийн эх үүсвэр

6.4.1. Шагнал, урамшууллын зардлыг батлагдсан төсөв, багш, ажилтны цалингийн сан, хандив, төсөл, хөтөлбөрийн эх үүсвэр, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

6.5. Мөнгөн урамшуулалд холбогдох татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу суутган тооцно.

6.6. Давхар шагнал, хугацаа

6.6.1. Шагнал, мөнгөн урамшууллыг нэг ижил үндэслэл, үр дүнд давхардуулан олгохгүй.

6.6.2. Ижил төрлийн шагналын хоорондын хугацаа 3-аас доошгүй жил байна.

6.6.3. Судалгаа, эрдэм шинжилгээ, инновацын шагнал, урамшуулалд 6.6.2 дахь заалт хамаарахгүй.

6.7. Бүртгэл, архив

6.7.1. Шагнагдсан болон нэр дэвшигчийн мэдээллийг нэгдсэн цахим санд хариуцсан хүний нөөцийн мэргэжилтэн, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлын туслах бүртгэнэ.

6.7.2. Шагнал, урамшуулалтай холбоотой шийдвэр, материал, үнэлгээний мэдээлэлтэй холбоотой баримт бичгийг ажлын хэсэг архивд хадгална.

ДОЛОО.БУСАД

7.1. Нэр дэвшигч нь шагнал, урамшуулалтай холбоотой гомдол гаргасан тохиолдолд холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.

7.2. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-0000-

Шагнал урамшууллын ерөнхий болон тусгай шалгуур

Хүндэтгэлийн болон ёслолын шагнал

	Тодорхойлолт	Ерөнхий шалгуур	Тусгай шалгуур
1	“Эрдмийн элч” медаль нь Монгол Улсын Их Сургуулийн дээд шагнал бөгөөд шинжлэх ухаан, боловсрол, инновац, олон улсын хамтын ажиллагааны хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан эрдэмтэн, багш, судлаачид олгоно.	1. шинжлэх ухаан, боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан байх; 2. үндэсний болон олон улсын хэмжээнд академик нэр хүндтэй байх; 3. Монгол Улсын Их Сургуулийн хөгжил, нэр хүндэд бодит хувь нэмэр оруулсан байх; 4. Судалгаа, эрдэм шинжилгээ, сургалтын чиглэлээр онцгой үр дүн гаргасан байх;	Нэр дэвшигч нь дараах шалгуурыг хангасан байна: 1. олон улсын өндөр түвшний судалгааны бүтээлтэй байх; 2. шинжлэх ухааны эшлэлийн өндөр үзүүлэлттэй байх; 3. шинэ мэдлэг, онол, арга зүй бий болгосон байх; 4. олон улсын судалгааны төсөл удирдсан байх; 5. шинжлэх ухааны салбарт хүлээн зөвшөөрөгдсөн байх. Нэр дэвшигч нь дараах хувь нэмрийг оруулсан байна: 1. сургалт, судалгааны шинэ чиглэл хөгжүүлсэн байх; 2. лаборатори, төв, хөтөлбөр байгуулахад манлайлан оролцсон байх; 3. олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлсэн байх; 4. залуу судлаач, багш бэлтгэхэд бодит хувь нэмэр оруулсан байх; байгууллагын олон улсын нэр хүндийг өсгөсөн байх.
2	МУИС-ийн Хүндэт дэвтэрт нэрийг нь бичиж алдаршуулах	Нэр дэвшигч нь дараах шалгуурыг хангасан байна: 1. Монгол Улсын Их Сургуульд 28-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх; 2. байгууллагын хөгжил, сургалт, судалгаа, удирдлага, хамтын ажиллагаанд тогтвортой бөгөөд бодит хувь нэмэр оруулсан байх; 3. хамт олны дунд нэр хүндтэй, үлгэр дуурайлал болсон байх; 4. академик болон хөдөлмөрийн ёс зүйг сахин ажилласан байх; 5. байгууллагын үнэт зүйл,	Дараах шалгуурыг харгалзан үзнэ: 1. шинэ хөтөлбөр, тэнхим, лаборатори, төв байгуулахад оролцсон байх; 2. олон үеийн багш, судлаач, суралцагч бэлтгэсэн байх; 3. байгууллагын нэр хүндийг өсгөсөн байх; 4. төр, олон улсын түвшний шагнал хүртсэн байх; 5. байгууллагын түүхэн хөгжилд онцгой мөр үлдээсэн байх.



		уламжлалыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулсан байх.	
3	“Хүндэт жуух” Монгол Улсын Их Сургуулийн хөгжил, стратеги төлөвлөгөө, сургалт, судалгаа, үйлчилгээний зорилтыг хэрэгжүүлэхэд үр бүтээлтэй ажилласан багш, ажилтан, суралцагч, хамтран ажиллагч байгууллага, хувь хүнд олгох хүндэтгэлийн шагнал мөн.	Багш, ажилтан нь дараах шалгуурыг хангасан байна: 1. Монгол Улсын Их Сургуульд 6-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх; 2. стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI)-ийг ханган биелүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан байх; 3. ажлын чанар, бүтээмж, үр дүнгээр хамт олондоо үлгэр жишээ болсон байх; 4. байгууллагын соёл, хамтын ажиллагаа, ёс зүйг сахин ажилласан байх; 5. сургалт, судалгаа, үйлчилгээ, удирдлага, инновацын чиглэлээр тодорхой үр дүн гаргасан байна.	Хамтран ажиллагч байгууллагыг туслах зорилго Хамтран ажиллагч байгууллага, хувь хүн нь дараах шалгуурыг хангасан байна: 1. Монгол Улсын Их Сургуультай 3-аас доошгүй жил тогтвортой хамтран ажилласан; 2. сургалт, судалгаа, инновац, суралцагчийг дэмжих үйл ажиллагаанд бодит хувь нэмэр оруулсан; 3. байгууллагын нэр хүнд, хамтын ажиллагааны хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн байна.
4	“Баярын бичиг” Монгол Улсын Их Сургуулийн үйл ажиллагаа, хамт олны хөгжил, сургалт, судалгаа, үйлчилгээ, олон нийтийн ажилд идэвх санаачилгатай, үр бүтээлтэй оролцсон багш, ажилтан, суралцагч, хамтран ажиллагч байгууллага, хувь хүнд олгох хүндэтгэлийн шагнал мөн.	“Баярын бичиг”-т нэр дэвшигч нь дараах шалгуурыг хангасан байна: 1. Монгол Улсын Их Сургуульд 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх; 2. байгууллагын үйл ажиллагаа, хамт олны хөгжилд идэвхтэй оролцсон байх; 3. байгууллагын үнэт зүйл, ёс зүй, хамтын ажиллагааг дэмжин ажилласан байх; 4. байгууллагын нэр хүндэд эерэг нөлөө үзүүлсэн байх;	Хамтран ажиллагч байгууллага, хувь хүн нь дараах шалгуурыг хангасан байна: 1. байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн; 2. хамтын ажиллагаанд идэвхтэй оролцсон; 3. сургалт, судалгаа, оюутны хөгжилд хувь нэмэр оруулсан байна.

Гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшуулал

	Тодорхойлолт	Ерөнхий шалгуур	Тусгай шалгуур	оноо /100/	Нотлох баримт /бүрдүүлэх материал/
5	Оны шилдэг багш				
	Монгол Улсын Их Сургуулийн стратеги төлөвлөгөө, сургалтын чанар, судалгаа, инновац, оюутны хөгжил, байгууллагын үнэт зүйлсийг хэрэгжүүлэхэд өндөр үр дүн гаргасан багшийг шалгаруулан олгох гүйцэтгэлд суурилсан урамшуулал мөн.	1. Монгол Улсын Их Сургуульд үндсэн багшаар 5-аас доошгүй жил ажилласан; 2. тухайн жилийн хөдөлмөрийн гүйцэтгэлийн үнэлгээ хангалттай буюу түүнээс дээш үнэлэгдсэн; 3. сургалт, судалгаа, оюутны хөгжилд үр бүтээлтэй ажилласан; 4. байгууллагын нэр хүндэд эерэг нөлөө үзүүлсэн байна.	Оюутны хичээлийн үнэлгээ Сургалтын чанар, үр дүн Сургалтын шинэ арга Хөтөлбөр шинэчлэл Сурах бичиг, гарын авлага Судалгааны бүтээл Оюутан удирдсан байдал Мэргэжлийн хөгжил Байгууллагын оролцоо Ёс зүй, харилцаа	15 15 10 10 10 15 10 5 5 5	Сиси-гээс баримт Тайлан, KPI LMS, контент Тушаал, тайлан ISBN, эх хувь хэвлэгдсэн бүтээл Удирдсан ажил Сертификат Тайлан УАТ-ын тодорхойлолт
6	Оны шилдэг ажилтан	Монгол Улсын Их Сургуулийн стратеги төлөвлөгөө, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үйлчилгээний чанар, бүтээмж, дижитал хөгжил, хамтын ажиллагааг сайжруулахад өндөр үр дүн гаргасан захиргааны ажилтанд олгох гүйцэтгэлд суурилсан урамшуулал мөн.	Монгол Улсын Их Сургуульд 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан; 1. тухайн жилийн хөдөлмөрийн гүйцэтгэлийн үнэлгээ хангалттай буюу түүнээс дээш үнэлэгдсэн байх; 2. байгууллагын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангахад бодит хувь нэмэр оруулсан байх; 3. байгууллагын ёс зүй, хөдөлмөрийн сахилгыг мөрдөн ажилласан байх; 4. байгууллагын нэр хүндэд эерэг нөлөө үзүүлсэн байх.	25 20 15 15 10 10 5	KPI тайлан Тайлан Санал асуулга Нотлох баримт Систем, тайлан Тодорхойлолт УАТ-ын тодорхойлолт

7	Оны шилдэг үйлчилгээний ажилтан					
	Монгол Улсын Их Сургуулийн сургалт, судалгаа, үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг дэмжих цэвэр, аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэхэд үр бүтээлтэй ажилласан үйлчилгээний ажилтанд олгох гүйцэтгэлд суурилсан урамшуулал мөн.	Монгол Улсын Их Сургуульд 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх; 1. хөдөлмөрийн сахилга, ажлын байрны дэг журмыг мөрдөн ажилласан байх; 2. цэвэрлэгээ, үйлчилгээний чанар, хариуцлагаараа хамт олондоо үлгэр жишээ болсон байх; 3. байгууллагын соёл, хамтын ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсэн байх; 4. ёс зүй, сахилгын зөрчилгүй байх.	Цэвэрлэгээ, үйлчилгээний чанар Хөдөлмөрийн сахилга, цаг ашиглалт Эрүүл ахуй, аюулгүй байдал Хариуцлага, ажлын бүтээмж Харилцаа, үйлчилгээний соёл Шинэ санал, сайжруулалт Ёс зүй, хамтын ажиллагаа	30 15 15 15 10 10 5	Хяналтын үнэлгээ Ирц, НР Хяналтын тайлан	


Хамтын ажиллагааны шагнал

	Тодорхойлолт	Ерөнхий шалгуур	Тусгай шалгуур	Оноо /100/	Нотлох баримт /бүрдүүлэх материал/
8	Шилдэг түнш өргөмжлөл Монгол Улсын Их Сургуулийн сургалт, судалгаа, инновац, оюутны хөгжил, нийгмийн хариуцлага, олон улсын хамтын ажиллагааны хөгжилд бодит хувь нэмэр оруулсан байгууллага, аж ахуйн нэгж, хамтран ажиллагч түншид олгох хамтын ажиллагааны шагнал мөн.	1. Монгол Улсын Их Сургуультай тогтвортой хамтран ажилласан байх; 2. хамтын ажиллагааны хүрээнд бодит үр дүн гаргасан байх; 3. байгууллагын нэр хүнд, хөгжилд эерэг нөлөө үзүүлсэн байх; 4. хууль тогтоомж, гэрээний үүргээ зөрчөөгүй байх; 5. хамтын ажиллагааны ёс зүй, хариуцлагыг хангасан байх.	Хамтын ажиллагааны тогтвортой байдал Сургалт, судалгаанд оруулсан мөнгөн хөрөнгө оруулалт Сургалт, судалгаанд оруулсан мөнгөн бус хөрөнгө оруулалт Оюутан, багш дэмжсэн байдал Олон улсын хамтын ажиллагаа Байгууллагын нэр хүндэд үзүүлсэн нөлөө	20 30 20 10 10 10	Хамтын ажиллагааны гэрээ Оруулсан хөрөнгийн хэмжээ Оруулсан хөрөнгийн хэмжээ Тэтгэлгийн тушаал Төсөл, төслийн тайлан холбогдох баримт, тодорхойлолт

Судалгаа, эрдэм шинжилгээ, инновацын шагнал, урамшуулал

	Тодорхойлолт	Ерөнхий шалгуур	Тусгай шалгуур	Оноо /100/	Нотлох баримт /бүрдүүлэх материал/
9	Шилдэг патент, ашигтай загварын урамшуулал				
	Тайлант хугацаанд үндэсний болон олон улсын хэмжээнд бүртгүүлж хамгаалуулсан, шинжлэх ухаан, технологийн шинэ шийдлийг агуулсан, үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэмд ашиглах боломжтой патент, ашигтай загвар бий болгосон багш, судлаач, суралцагч, хамтарсан багт олгох урамшуулал.	1.Шинжлэх ухаан, технологийн шинэ шийдэл агуулсан байх. 2.Үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгмийн хэрэглээнд ашиглах боломжтой байх. 3.Олон улсын хэмжээнд хамгаалалт авсан бол давуу үнэлгээтэй байна. 4.Технологи дамжуулах, лицензжүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжтой байх. 5.МУИС-ийн инновацын нэр хүндийг өсгөсөн байх.	Шинэлэг байдал Патентын түвшин (үндэсний/олон улсын) Хэрэглээний боломж Эдийн засгийн үр өгөөжийн боломж Технологи дамжуулалтын боломж МУИС-д үзүүлэх стратегийн ач холбогдол	25 20 20 15 10 10	1) Нэр дэвшүүлэх санал 2) Патент, ашигтай загварын гэрчилгээний хуулбар 3) Патентын тодорхойлолт, хураангуй 4) Патентын хэрэглээний боломжийн тайлбар 5) Зохиогчийн бүрэлдэхүүний мэдээлэл 6) Бусад нотлох материал
10	Шилдэг инновац, технологи дамжуулалтын үр дүнгийн урамшуулал				
	Судалгааны түвшнээс хэрэглээнд амжилттай шилжсэн шийдэл буюу лиценз, спин – офф, технологи шилжүүлэлт, эсвэл нийгэмд ашиг тустай үр дүн боловсруулсан багш, судлаач, суралцагч, хамтарсан багт олгох урамшуулал.	1. Лицензийн гэрээ байгуулсан. 2. Технологи дамжуулах гэрээ байгуулсан. 3. Спин-офф эсхүл гарааны компани байгуулсан. 4. Үйлдвэрлэл, үйлчилгээ, төрийн бодлого, нийгмийн практикт нэвтрүүлсэн. 5. Орлого, эдийн засгийн үр өгөөж бий болгосон. 6. Нийгмийн ач холбогдолтой үр дүн бий болгосон.	Технологийн бэлэн байдлын түвшин Технологи дамжуулалтын үр дүн Лиценз, гэрээ, хамтын ажиллагаа Эдийн засгийн үр өгөөж Нийгмийн үр нөлөө	20 20 20 20 10	1) Нэр дэвшүүлэх санал 2) Технологийн товч танилцуулга 3) Лицензийн гэрээ, технологи дамжуулалтын гэрээний хуулбар 4) Спин-офф компанийн бүртгэлийн баримт (хамаарах бол) 5) Орлого, эдийн засгийн үр өгөөжийн мэдээлэл

[illegible]



Шагналд дагалдах мөнгөн урамшуулал, олгох хугацаа

Хүндэтгэлийн болон ёслолын шагнал

ATA13089 9104399
9024080427

	Шагнал, урамшууллын төрөл	Мөнгөн урамшуулал	Шагналын хэлбэр	Олгох хугацаа	Зохион байгуулах нэгж
1	“Эрдмийн элч” медаль	4,000,000	Медаль, мөнгөн урамшуулал	Багш нарын баяр	Хүний нөөц хариуцсан нэгж
2	МУИС-ийн Хүндэт дэвтэрт нэрийг нь бичиж алдаршуулах	1,000,000	Хүндэт дэвтэрт нэрийг нь бичих, мөнгөн урамшуулал		
3	“Хүндэт жуух”	100,000	Хүндэт жуух, мөнгөн урамшуулал	Шинэ жил, тэмдэглэлт ой	
4	“Баярын бичиг”	50,000	Баярын бичиг, мөнгөн урамшуулал		

Гүйцэтгэл, үр дүнд суурилсан урамшуулал

	Шагнал, урамшууллын төрөл	Мөнгөн урамшуулал	Шагналын хэлбэр	Олгох хугацаа	Зохион байгуулах нэгж
5	Оны шилдэг багш	1 сарын цалин	Өргөмжлөл, Мөнгөн урамшуулал	Шинэ жил	Хүний нөөц хариуцсан нэгж, Сургалтын нэгж
6	Оны шилдэг ажилтан	1 сарын цалин			
7	Оны шилдэг үйлчилгээний ажилтан	1 сарын цалин			

Хамтын ажиллагааны шагнал

	Шагнал, урамшууллын төрөл	Мөнгөн урамшуулал	Шагналын хэлбэр	Олгох хугацаа	Зохион байгуулах нэгж
8	Шилдэг түнш өргөмжлөл	-	өргөмжлөл; дурсгал;	Шинэ жил, тэмдэглэлт ой	Хамтын ажиллагаа хариуцсан нэгж

Судалгаа, эрдэм шинжилгээ, инновацын шагнал, урамшуулал

	Шагнал, урамшууллын төрөл	Мөнгөн урамшуулал	Шагналын хэлбэр	Олгох хугацаа	Зохион байгуулах нэгж
9	“Өндөр импакт бүхий бүтээлийн урамшуулал”	5,000,000	Мөнгөн урамшуулал	Багш нарын баяр /Шинжлэх ухааны ажилтны өдөр	Эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан нэгж
10	Шилдэг бүтээлийн урамшуулал /нэгдүгээр зохиогч, холбоо барих зохиогч/				
	Q1 ангиллын сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл	1,500,000			
	Q2 ангиллын сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл	1,000,000			
	Q3 болон Q4 ангиллын сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл	500,000			
11	Шилдэг бүтээлийн урамшуулал /хамтран зохиогч/				
	Q1 ангиллын сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл	750,000			
	Q2 ангиллын сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл	500,000			
	Q3 болон Q4 ангиллын сэтгүүлд хэвлүүлсэн бүтээл	200,000			
12	Шилдэг патент, ашигтай загварын урамшуулал	3,000,000			
13	Шилдэг инновац, технологи дамжуулалтын үр дүнгийн урамшуулал	3,000,000			



МУИС-ИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ БАГШ, АЖИЛТНЫ ТАНИЛЦУУЛГА

1. Ургийн овог
2. Эцэг, эхийн нэр
3. Өөрийн нэр
4. Регистрийн дугаар
5. Нас, хүйс
6. Яс, үндэс
7. Үндсэн захиргаа



8. Боловсрол

д/д	Төгссөн сургууль	Суралцсан хугацаа	Эзэмшсэн боловсрол, мэргэжил
1			
2			
3			

9. Ажил эрхэлсэн байдал /он дарааллаар/

д/д	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа /он сараар/	Эрхэлсэн ажил албан тушаал
1			
2			

10. Нийт ажилласан жил:

- Үүнээс: Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт:
- Тухайн хамт олон дотроо ажилласан жил:

11. Шагнагдаж байсан шагналууд /оны дарааллаар баримтлан бичих бөгөөд Яамны бусад шагналаар шагнагдсан бол түүний хуулбарыг заавал хавсаргана/

д/д	Шагналын нэр	Шагнагдсан он

12. Шагнуулах үндэслэл: /Товч, тодорхой бичнэ/

13. Тухайн ажилтны ажил мэргэжлийн ур чадвар, үйл ажиллагаа, мэргэшлийн түвшний үнэлгээ: /сүүлийн 3 жилээр/

14. Ямар шагналд нэр дэвшүүлж буй санал:

15. Хамт олны саналын хувь:

16. Байгууллагын холбоо барих ажилтны нэр:

Утас: